

- 3.1.в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах
 3.1.д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах
 3.3.6. Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонссоноо харуулах
 3.4.6. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх

3-р ангийн “Монгол хэл” хичээлийн мэдлэг шалгах даалгавар

2021.04.09

1. “Муу даа” зохиолын баатруудыг нэрлэж бичээрэй.

Муу даа

Айсандаа үсээ өрвийлгөж, хашааны ёроол руу шигдсэн муурын бяцхан зулзагыг нохой ууртайгаар боргоож байлаа. Муурын зулзага амаа ангайлган өрөвдөлтэйгээр орилох ажээ. Хажуухантай нь хоёр хүүхэд тэдний яахыг нь сонирхон хүлээнэ.

Гэтэл цонхоор нэг бүсгүй тэднийг харангуут довжоон дээрээ яаран гарч ирээд, нохойг хөөлөө. Чингэснээ хүүхдүүдэд хандан:

- Та нарын санаа яасан зовдоггүй юм! гэж ууртай гэгч хашгирав.
- Юунд санаа зовох гэж! Бид яагаа ч үгүй шүү дээ! гэж тэднийг гайхахад:
- Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу байна даа гэж тэр бүсгүй ууртай хэлжээ.

Зохиолын баатрууд :

Дараахь хүүхдүүдэд сэтгэл хөдлөлийн ямар шинж илэрч байгааг доор нь бичээрэй.



2. “Боргоох” гэсэн үгийн утга аль нь вэ?

А. Цохих Б. Хуцах В. Гүйх Г. Хазах

3. Амьд биеийг олоорой. Тэрэнд хэн тусалсан бэ?

А. хүүхдүүд Б. Нохой В. бүсгүй Г. зулзаганы эх



4. Зохиолд анхааруулах өгүүлбэр хэд байна вэ?

А. 1 Б. 2 В. 3 Г. 4

5. Хэрэв чи байсан бол муурын зулзаганд туслах байсан уу?

.....

.....

6. Дараах баатруудын зан чанарыг харуулсан хэсгийг зохиолоос олж бичнэ үү.

Муурын зулзага-.....

Нохой-.....

7. Ертөнций гурвыг зохион бичээрэй.

.....нэг хар
нэг хар
нэг хар

8. Оньсогыг хариутай нь зөв холбоорой.

Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй.	☐	
Сээр шиг нугалж Сэмж шиг дэлгэдэг,	☐	
Эгч дүү хоёр Эн чацуухан.	☐	
Сар шиг дугуй, Сэмж шиг садархай	☐	
Урт хүн уландаа үстэй.	☐	
Ишигний эвэр ийшээ тийшээ.	☐	
Гүн худгийн гүйдэг могой хүчтэнээс хамгаална.	☐	

9. “Хэрвээ би шидтэн байсан бол” 4 мөрт шүлэг зохиогоорой